



177

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 8/135

Ховд

Н.Алтанцэцэгийг ажилд томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 44.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Засгийн газрын 2022 оны “Хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 417 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засгийн газрын Тохируулагч агентлаг - Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг татан буулгасантай холбогдуулан Нямдаваагийн Алтанцэцэгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагчаар 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн шилжүүлэн томилсугай.


2. Н.Алтанцэцэгийг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Түмэндэмбэрэл)-д үүрэг болгосугай.

3. Н.Алтанцэцэгийн албан хэрэгцээнд хэрэглэж байсан хөрөнгө болон холбогдох бусад бичиг баримтыг хүлээн авч бүртгэлд тусган ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын нярав (Х.Болормаа), нягтлан бодогч (Б.Энхмандал) нарт даалгасугай.

4. Н.Алтанцэцэгийг Засгийн газрын 2019 оны “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ”-ний ТЗ-6-2 дахь шатлал буюу 731527 (долоон зуун гучин нэгэн мянга таван зуун хорин долоо) төгрөгөөр цалинжуулахыг Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч (Б.Нямдэлгэр)-д зөвшөөрсүгэй.

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


Б.БАЯРСҮХ



Scanned with  
Tush B/135 Ba

178

Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
даргын 2022 оны 12 дугаар сарын 30-ны  
өдрийн Б/135 дугаар тушаалын хавсралт



### ХӨРӨНГӨ ХҮЛЭЭЖ АВАХ АЖЛЫН ХЭСЭГ

- Ажлын хэсгийн  
ахлагч: Б.Нямдэлгэр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү,  
аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий  
нягтлан бодогч)
- Гишүүд: Б.Энхмандал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
нягтлан бодогч)  
Н.Баянжаргал (Мэргэжлийн хяналтын газрын нягтлан  
бодогч)  
А.Нямцэцэг (Мэргэжлийн хяналтын газрын нярав)
- Нарийн бичгийн  
дарга: Х.Болормаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын нярав)

-oOo-